



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Иргэдийн бүлэг ажиллуулах тухай

Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.6 дахь заалт, Хот тосгоны эрхзүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.4, 16.5.5 дахь заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" А/18 дугаар тушаалын 3 дугаар хавсралт, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2017 оны "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийг батлах тухай" 01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны "Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг дүгнэх, 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай" 19/16 дугаар тогтоолын хавсралтын 3-52 дугаар заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны 279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1 дэх заалт, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.9.5, 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэдийн оролцоотой хөгжлийн жил болгон зарласантай холбогдуулан нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөс, хөл газрын ургамлын цэвэрлэгээ үйлчилгээнд иргэдийг оролцуулах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зорилгоор гэр хорооны ажилгүй иргэд, цагаар ажиллах хүсэлтэй оюутан залуучуудыг иргэдийн бүлгийн зохион байгуулалтад оруулж, цагийн ажлын системээр ажиллуулах, тэдний өдөр тутмын ажлыг хөндлөнгийн хяналтын Төрийн бус байгууллагаар хянуулах ажлыг зохион байгуулахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.


2. Иргэдийн бүлэг ажиллуулах ажлын цагийн тоо хэмжээг 1 дүгээр хавсралтаар, иргэдийн бүлгийн ажлыг зохион байгуулахад шаардагдах зардлын тооцоог 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

3. Иргэдийн бүлэг ажиллуулахад шаардагдах 792,235,923 /Долоон зуун ерэн хоёр сая хоёр зуун гучин таван мянга есэн зуун хорин гурван/ төгрөгийг хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх төслүүдийг санхүүжүүлэх зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 01 сарын 23 өдрийн
017..... тушаалын 1 дүрэм хавсралт



ИРГЭДИЙН БҮЛЭГ АЖИЛЛУУЛАХ
АЖЛЫН ЦАГИЙН ТОО ХЭМЖЭЭ

№	Дүүргүүд	Хорооны тоо	1 сард 1 хороонд ноогдох ажлын цаг	1 сарын нийт ажлын цаг	Ажиллах сар	Нийт ажиллах цаг
1	Баянгол	8	160	1,280	11	14,080
1.1	Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ	8	160	1,280	11	14,080
2	Баянзүрх	20	160	3,200	11	35,200
2.1	Нийтлэг үйлчилгээний газар-1	5	160	800	11	8,800
2.2	Нийтлэг үйлчилгээний газар-2	2	160	320	11	3,520
2.3	Нийтлэг үйлчилгээний газар-3	6	160	960	11	10,560
2.4	Нийтлэг үйлчилгээний газар-4	7	160	1,120	11	12,320
3	Сонгинохайрхан	23	160	3,680	11	40,480
3.1	Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ ОНӨААТҮГ	13	160	2,080	11	22,880
3.2	Тээвэрлэлт үйлчилгээний төв ОНӨААТҮГ	8	160	1,280	11	14,080
3.3	Улаанбаатар шинэчлэл ХХК	2	160	320	11	5,280
4	Сүхбаатар	11	240	2,640	11	29,040
4.1	СБ дэвшил ОНӨААТҮГ	6	240	1,440	11	15,840
4.2	СБ тохижилт ХХК	3	240	720	11	7,920
4.3	УБ шинэчлэл ХХК	1	240	240	11	2,640
4.4	Сүзүки юмэ ХХК	1	240	240	11	2,640
5	Хан-Уул	11	160	1,760	11	19,360
5.1	Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ	6	160	960	11	10,560
5.2	Хан-Уул агро ОНӨААТҮГ	5	160	800	11	8,800
6	Чингэлтэй	13	240	3,120	11	34,320
6.1	Тохижилт үйлчилгээ ХХК	10	240	2,400	11	26,400
6.2	Найши трейд ХХК	3	240	720	11	7,920
7	Багануур	5	160	800	11	8,800
7.1	"Автожим" ОНӨААТҮГ	5	160	800	11	8,800
8	Багахангай	2	160	320	11	3,520
8.1	"Тохижилт үйлчилгээний алба" ОНӨААТҮГ	2	160	320	11	3,520
9	Налайх	7	160	1,120	11	12,320
9.1	"Налайх тохижилт" ОНӨААТҮГ	7	160	1,120	11	12,320
ДҮН		100		24,000		197,120

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 01 сарын 23 өдрийн
А/17..... тушаалын дүгнэлт хавсралт



ИРГЭДИЙН БҮЛГИЙН АЖЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /ширхэг/	Нэгж үнэ /төг/	Нийт зардал /төг/
1	Иргэдийн бүлэг ажиллуулах зардал /1 цагийн ажлын хөлс 3400₮ ба үүн дээр иргэдийн бүлэг ажиллуулсан байгууллагаас төлөх НДШ-ийн 14,5%, хяналтын 2%-ийг нэмж тооцов/	цаг	197,120	3,971	782,735,923
2	Бээлий худалдан авах зардал	ширхэг	2500	1,800	4,500,000
3	Хантааз хийлгэх зардал	ширхэг	250	20,000	5,000,000
Нийт					792,235,923